



АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ДАРГА Л.ЭРДЭНЭХҮҮ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/295
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Ахмад настны үндэсний төвийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Ахмад настны үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\02226AG18.Docx

07.03.01



АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГазрын дарга: Ц. Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер: Я. Самбууням
Утас: 260512

Аудитор: Б. Баярмаа
Утас: 260512

Үндэсний Аудитын Газар
Засгийн газрын ҮБайр
Бага тойруу 6
Улаанбаатар-46
Монгол улс
Цахим хуудас: www.audit.mn

“Юнистар” Аудит ХХК
Захирал: М. Энхжаргал
Утас: 99168961328735
Цахим хаяг:
unistar_audit@yahoo.com
Аудитор: Т. Энхтуяа
Утас: 96685259

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Аудит хийсэн төсвийн
гүйцэтгэлийн тайлан

2017 оны 2 дугаар сар



АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг түвшин
6. Дотоод хяналт
7. Шилэн дансны мэдээлэл
8. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт



1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дүгээр заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Ахмад настны үндэсний төвийн үйл ажиллагааны 2016оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ/2017/75/СТА-ТШЗ / аудит хийлээ.

АудитыгТөсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв. Ахмад настны үндэсний төвийн үйл ажиллагааны2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Ахмад настны үндэсний төвийн үйл ажиллагааны2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дүгээр сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн “Юнистар Аудит” ХХК-ийнчанарын хяналтын менежер Д. Сүхээ, аудитор Т. Энхтуяа, аудиторын туслах М. ЦэцэгсүрэнЭ. Амарбаатар нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Ахмад настны үндэсний төв нь2016 оны санхүүгийн тайланг 2017оны 01дүгээр сарын 24-нд “ Юнистар Аудит ” ХХК-д ирүүлсэн.

“Юнистар Аудит “ ХХКнь аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017оны 02 дугаар сарын 25-нд Ахмад настны үндэсний төвийн удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын“Төсвийн тухай хууль”/нэмэлт өөрчлөлт орсон/, “Төрийн албаны тухай хууль”/нэмэлт өөрчлөлт орсон/, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Төрийн аудитын тухай хууль”, “Нийгмийн даатгалын тухай хууль”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”,“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Шилэн дансны тухай хууль”-иуд болон эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоол,Хүн Амын Хөгжил, Нийгмийн хамгааллын яамны сайдын тушаал, Сангийн сайдын тушаал, бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.



3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Танилцуулга

Улсын асрамжийн газар нь 1924 онд байгуулагдсан бөгөөд 92 жилийн турш өндөр настнуудыг асарч, сувилах ажлыг гүйцэтгэж байна. Улсын асрамжийн газар нь улсаас санхүүждэг бөгөөд Улсын их хурлаас баталсан “Нийгмийн халамжийн тухай” хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг ахмад настны төрөлжсөн асрамжийн газар юм. Улсын асрамжийн газар нь 2013 оны 3 дугаар сараас эхлэн Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төв гэсэн нэртэйгээр үйл ажиллагааг үргэжлүүлэн явж байсан. Одоо Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 55 тооттогтоолоор Ахмад настны төв гэж нэрээ өөрчлөн үйл ажиллагааныхаа чиглэлийг өргөжүүлсэн байна. Ахмад настны үндэсний төв нь 150 хүний ортой ахмад настны сувилал, 100 хүн хүлээн авах өргөтгөлийн барилгыг ашиглалтанд оруулж үйл ажиллагаагаа нэмэгдүүлсэн.

Үйлчилгээний чанарыг сайжруулж, нарийн мэргэшсэн туршлагатай баг хамт олныг бүрдүүлж ажиллах, уг төвийг орчин үеийн техник тоног төхөөрөмжөөр хангаж, аюулгүй, чанартай үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх, үйлчлүүлэгчдийн нийгэм, соёл, оюун санаа болон нөхөн сэргээх нөөц бололцоог олгож тэднийг бүрэн хөгжүүлж нийгэмшүүлэх, эмнэлгийн анхан шатны тусламж, хөнгөвчлөх эмчилгээ үргэлжлүүлэн урт хугацаагаар асрах зэрэг үйлчилгээг орчин үеийн стандартад нийцүүлэн ажиллах.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангах ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагч байна, 16.4.18-д “Төсвийн бусад байгууллагын дарга /захирал эрхлэгч/ тухайн байгууллагын төсвийн захирагч байна” гэж заасны дагуу Ахмад настны үндэсний төвийнд аргатөсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Ахмад настны үндэсний төвийн 2016 оны төсвийг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яамны төрийн сангаас олгож байна.

Ахмад настны үндэсний төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Ахмад настны үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан горим, сорил 23-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/



Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны сайдын 2009 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 104 тоот тушаалаар батлагдсан нэгдсэн *ᠶᠠᠳᠥᠭᠠᠢ ᠠᠶᠢ᠋ᠨ ᠠᠵᠳᠠᠭᠤᠨ* бодлогын баримт бичгийн дагуу санхүүгийн тайлангаа гаргадаг. Тус газар нь Санхүүгийн тооцооллын ACOLOURS санхүүгийн програмаар санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлээ хөтөлж байна.

5. Материаллаг байдал:

Бид санхүүгийн тайланд материаллаг байдлыг авч үзэхдээ нийт төсвийн санхүүжилтийн хэмжээ байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлно гэж үзээд орлогын тайлангийн материаллаг түвшинг орлогын 1 хувиар буюу алдааг хүлээн зөвшөөрөх нийт хэмжээг 108.1 сая төгрөгөөр тооцоолов. /ТАБ-СТА-В-1/

6. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Ахмад настны үндэсний төвийн үйл ажиллагааны санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл, журналыг, үйл ажиллагааны санхүүгийн баримттай тулгах байдлаар аудит хийх явцад өмнөх аудитаар илэрч байсан зөрчил давтагдахгүй байгаа зэргээс үзэхэд санхүүгийн үйл ажиллагааг сайжирсан байна гэж дүгнэж байна.

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яамны төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Ахмад настны үндэсний төвийн төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс 2,022.1 сая төгрөгийн урсгал санхүүжилт батлагдсан бөгөөд тайлант онд 1,601.4 сая төгрөгийн санхүүжилт, 137.1 сая төгрөгийн хөрөнгийн болон бараа материалын хандив тусламжийн орлого, өөрийн туслах аж ахуйгаас 33.7 сая төгрөг, 9,008.6 сая төгрөгийн хөрөнгийн орлого, нэмэлт санхүүжилтээр 1.0 сая төгрөг нийт 10,809.2 сая төгрөгийн орлоготой ажиллаж, үүнээс урсгал зардалд 1,725.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

8. Шилэн дансны мэдээлэл

Ахмад настны үндэсний төв нь “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”, Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зарчмын дагуу 2016 онд 151 ширхэг мэдээллийг, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам болон сангийн яамны цахим хаягаар улирал бүрийн хуулийн хугацаанд тайлан мэдээг илгээж ажилласан байна. Үүнд тендерт оролцсон нарийн мэдээлэлийн тухай 14 удаа, 5 саяаас дээш худалдан авалт /Тендерийн худалдан авалт/-ын тухай 14 удаа,



Цалингийн зардлаас бусад 5 саяаас дээш зардлыг 12 удаа, 5 саяаас дээш орлогыг 2 удаа, Хөрөнгө зарцуулах эрхийн акт, гэрээ, тушаалыг 68 удаа, Бусад мэдээлэлийг 41 удаа тавьсан байна. Тус төв нь өөрийн вэб сайтгүй тул www.shilendans.gov.mn сайт болон мэдээллийн самбартаа цаасан хэлбэрээр байршуулсан байна. Шилэн кабелийн сүлжээ татагдаагүйгээс интернэтийн хурд бага байгаа тул мэдээлэл оруулах, солилцоход ихээхэн хүндрэлтэй байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 дансанд эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд хяналтын болон нарийвчилсан горим, сорил 23-ийг гүйцэтгэв.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Ахмад настны үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээнд байгаа эсэхийг тендерээр авсан бараа материал болон зарим нэгэн зардлын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Ахмад настны үндэсний төв нь 2016 онд хөрөнгө оруулалтаар 150 хүн хүлээн авах сувилалын барилга, 100 асруулагч хүлээн авах өргөтгөлийн нийт 8,982.5 сая төгрөгийн өртөгтэй барилгыг хүлээн авсан.

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй байна.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Тус байгууллага нь тайлант хугацааны эхэнд нийт 6.8 сая төгрөгийн авлагатай, тайлант хугацааны эцэст 2.6 сая төгрөгийн Төв аймгийн ЭМНДХэлтсээс авах авлага бүртгэсэн байна. Авлагаар бүртгэгдсэн 6.8 сая төгрөгийг Төв аймгийн сум дундын шүүхийн 2016.04.07-ны өдрийн 151/ШШ2016/00310 тоот тогтоолоор хэрэгсэхгүй болгосон тул авлагын үлдэгдлийг тайлант хугацааны үр дүнгийн тайланд найдваргүй авлагын зардлаар тусгасан байна. Тайлант хугацаанд үүссэн 2.6 сая төгрөгийн авлага нь Төв аймгийн ЭМНДХэлтэст тооцооны авлага үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8. -Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн: Авлага өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, авлагыг барагдуулах талаар зөвлөмж өгснийг хүлээн зөвшөөрсөн.

2. Бараа материалын үлдэгдэл нь өмнөх оноос 224.6 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь Төсвийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр



ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн:Шинээр ашиглалтанд орсон 2 барилга нийтдээ 200 гаруй хүн хүлээн авах хүчин чадалтай боловч бүрэн чадлаараа ажиллаж чадаагүй, 1-р сарын санхүүжилт орохгүй удааширалтай байдаг учир нөөц бүрдүүлсэн, худалдан авах зүйл ажиллагаа /тендерт/ хугацаа нэлээд шаардагдах тул нөөц бүрдүүлснээс бараа материалын үлдэгдэл өссөн. Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах талаар аудитын зөвлөмж өгсөн.

3. Тус байгууллага нь Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны сайдын 2009 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 104 тоот тушаалаар батлагдсан нэгдсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн өөрийн үйл ажиллагаанд тохируулан ажиллаж байгаа ч УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон аудитын тухай хууль, дүрэм, журмын өөрчлөлт, Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоол хүчингүй болж, УСНББОУС-17 буюу үндсэн хөрөнгийн стандартад заасны дагуу үндсэн хөрөнгийн элэгдлийн талаарх өөрчлөлтийг тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах" гэсэн заалтыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгсөн. Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам зааварт нийцүүлэн 2017 онд үндсэн хөрөнгийн элэгдэлийн талаар УСНББОУС 17-г дагаж мөрдөж ажиллахаар болсон.

12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Тайлант хугацаанд үүссэн 2.6 сая төгрөгийн авлага нь Төв аймгийн ЭМНДХэлтэст тооцооны авлага үүссэн байна.Тус байгууллагаас бүтцийн өөрчлөлтөөр ажлаас гарсан ажилтануудын тэтгэмжийг цалингийн сангаас олгосон учир шимтгэл бодсон байсныг дээд газраас буруу гэсэн. НДШ-ийн тайланд тусгаагүй учир 2.6 сая төгрөгийн авлага үүссэн. 2017 оны 1-р улиралд багтаан тооцоо дуусгахаар болсон учир дээрхи материаллаг бус алдаанууд нь залруулагдахааргүй байна.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Ахмад настны үндэсний төвийн2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.



15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Ахмад настны үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг түвшний хэмжээг 108.1 сая төгрөгөөр тогтоосон. Тухайн байгууллагын 6.8 сая төгрөгийн авлагад барагдуулах тухай зөвлөмж хүргүүлсэн. Тухайн зөвлөмжийн дагуу тайлангийн хугацаанд 6.8 сая төгрөгийн авлагыг Төв аймгийн сум дундын шүүхийн 2016.04.07-ны өдрийн 151/ШШ2016/00310 тоот тогтоолоор хэрэгсэхгүй болгосон тул авлагын үлдэгдлийг тайлант хугацааны үр дүнгийн тайланд найдваргүй авлагын зардлаар тусгасан байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Ахмад настны үндэсний төвийн 2015 оны санхүүгийн тайланд аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан.

16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Зөрчилгүй санал дүгнэлт

Ахмад настны үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан, менежементийн захидал, асуулгын бүртгэл, байгууллагын санхүүгийн тайлан болон судалгаа, саналын хуудсыг тус тус хавсаргав



**АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИН ТАЙЛАН**

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Тэргүүлэх ач холбогдол № 1

Тэргүүлэх ач холбогдол № 2

Асуудал 1

Авлага өглөгийн талаар3

Асуудал 2

Бараа материалын талаар.....4

Асуудал 3

НББББББичгийн талаар.....5



МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Ахмад настны үндэсний төвийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимд зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршин буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмжүүд маань дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан дарга, ерөнхий нягтлан бодогч, бусад ажилтнуудад талархал илэрхийлье.



Асуудал 1: Авлага өглөгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

Ажиглалт

Тус байгууллага нь тайлант хугацааны эхэнд нийт 6.8 сая төгрөгийн авлагатай, тайлант хугацааны эцэст 2.6 сая төгрөгийн НДБайгууллагаас авах авлага бүртгэсэн байна. 6.8 сая төгрөгийн авлагыг Төв аймгийн сум дундын шүүхийн 2016.04.07-ны өдрийн 151/ШШ2016/00310 тоот тогтоолоор хэрэгсэхгүй болсон тул авлагын үлдэгдлийг тайлант хугацааны үр дүнгийн тайланд найдваргүй авлагын зардлаар тусгасан байна. Тайлант хугацаанд үүссэн 2.6 сая төгрөгийн авлага нь НДбайгууллагад тооцооны авлага үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8. -Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэл

Найдваргүй болон эргэлзээтэй авлага үүсэх эрсдэлтэй. Иж, Э, Ү

Зөвлөмж

1. Төсвийн тухай хуулийн 6.4.8. - Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зарчмыг хэрэгжүүлэх
2. Авлага өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, авлага барагдуулж, авлага, өглөг үүсгэхгүй ажиллах

АНҮТ-ийн хариу

Бүтцийн өөрчлөлтөөр ажлаас гарсан ажилтануудын тэтгэмжийг цалингийн сангаас олгосон учир шимтгэл бодсон байсныг дээд газраас буруу гэсэн. НДШ-ийн тайланд тусгаагүй учир 2.6 сая төгрөгийн авлага үүссэн. 2017 оны 1-р улиралд багтаан тооцоо дуусгана.



Асуудал 2 Бараа материалын үлдэгдлийн өсөлтийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

Ажиглалт

Бараа материалын үлдэгдэл нь өмнөх оноос 224.6 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь Төсвийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэл

Бараа материалын нөөц их байх нь барааны чанар муудаж, хугацаа дуусах, зардал өсөх эрсдэлтэй. Ил, Х, Үн, Т

Зөвлөмж

1. Хэрэгцээндээ тохируулан бараа материал худалдаж авч байх

↓

ААХҮТ-ийн хариу

Бараа материалын үлдэгдэл өссөн шалтгаан нь:

1. Шинээр ашиглалтанд орсон 2 барилга нийтдээ 200 гаруй хүн хүлээн авах хүчин чадалтай боловч бүрэн чадлаараа ажиллаж чадаагүй учир
2. 1-р сарын санхүүжилт орохгүй удааширалтай байдаг учир нөөц бүрдүүлсэн.
3. Худалдан авах зүйл ажиллагаа /тендерт/ хугацаа нэлээд шаардагдах тул нөөц бүрдсэн.



Ажиглалт

Тус байгууллага нь Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны сайдын 2009 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 104 тоот тушаалаар батлагдсан нэгдсэн *íŷăðëàí áíäî ãĵððăŷëëéí* бодлогын баримт бичгийн өөрийн үйл ажиллагаанд тохируулан ажиллаж байгаа ч УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон аудитын тухай хууль, дүрэм, журмын өөрчлөлт, Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоол хүчингүй болж, УСНББОУС-17 буюу үндсэн хөрөнгийн стандартад заасны дагуу үндсэн хөрөнгийн элэгдлийн талаарх өөрчлөлтийг тусгаагүй байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Ахмад настны үндэсний төвийн хариу

Манай байгууллага Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам зааварт нийцүүлэн 2017 онд үндсэн хөрөнгийн элэгдэлийн талаар УСНББОУС 17-г дагаж мөрдөж ажиллах болно.



АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ

	Балансын зүйл	Тэм	Эхний үлдэгдэл	(Төгрөгөөр) Аудитлагдсан үлдэгдэл
ХӨРӨНГӨ				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө			-	-
АВЛАГА			6,832,437.00	2,643,007.93
Бусад байгууллагаас авах авлага			5,000,000.00	2,643,007.93
Хувь хүмүүсээс авах авлага			1,832,437.00	-
БАРАА МАТЕРИАЛ			169,001,850.65	393,626,666.92
Эм боох материал			5,994,225.65	22,326,646.52
Аж ахуйн материал			67,755,225.00	144,246,397.00
Түлш шатах тослох материал			2,790,000.00	2,973,800.00
Хангамжийн материал			35,462,500.00	69,553,400.00
Мал, амьтад			17,350,000.00	76,155,610.00
Хүнсний материал			39,649,900.00	78,370,813.40
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН			175,834,287.65	396,269,674.85
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ				
ҮНДСЭН ХӨРӨНГӨ			1,208,957,999.00	10,065,223,165.67
Биет хөрөнгө			1,208,187,999.00	10,064,453,165.67
барилга байгууламж			1,674,204,597.00	10,656,718,255.00
Хуримтлагдсан элэгдэл			(714,433,151.00)	(929,123,351.00)
авто тээврийн хэрэгсэл			183,380,000.00	208,598,764.00
Хуримтлагдсан элэгдэл			(41,007,510.00)	(70,569,610.00)
машин тоног төхөөрөмж			134,433,606.00	205,050,262.67
Хуримтлагдсан элэгдэл			(45,292,690.00)	(70,392,330.00)
Тавилга, аж ахуйн эд хогшил			30,148,970.00	85,291,970.00
Хуримтлагдсан элэгдэл			(13,245,823.00)	(21,120,795.00)
Биет бус хөрөнгө			770,000.00	770,000.00
Программ хангамж			770,000.00	770,000.00
Хуримтлагдсан элэгдэл				
НИЙТ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			1,208,957,999.00	10,065,223,165.67
НИЙТ ХӨРӨНГӨ			1,384,792,286.65	10,461,492,840.52
ӨР ТӨЛБӨР				
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР				
Өглөг			-	-
Татвартай хийх тооцоо				
Богино хугацаат өр төлбөрийн дүн			-	-
ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН			-	-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧ				
Засгийн газрын хувь оролцоо			870,065,632.00	870,065,632.00
өмнөх үеийн үр дүн			67,488,197.37	30,789,464.65
Тайлант үеийн үр дүн			(36,698,732.72)	9,076,700,553.87
дахин үнэлгээний зөрүү			483,937,190.00	483,937,190.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН			1,384,792,286.65	10,461,492,840.52
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН			1,384,792,286.65	10,461,492,840.52



АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН **АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ** **төгрөгөөр/**

	Тэм	Өмнөх он	Аудитлагдсан
ТАТААС БА САНХҮҮЖҮҮЛЭЛТИЙН ОРЛОГО		963,364,073.00	10,610,962,303.67
Улсын төсвөөс		963,364,073.00	10,610,962,303.67
урсгал		941,341,479.00	1,601,388,215.00
төсвийн хуваарилагдаагүй нөөц хөрөнгө		22,022,594.00	9,009,574,088.67
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО		35,974,543.77	198,209,650.00
Төсвийн хэмнэлтээс		1,781,404.77	-
Туслах аж ахуйгаас		7,535,800.00	33,705,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		26,657,339.00	27,416,500.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН 1		999,338,616.77	137,088,150.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ			10,809,171,953.67
АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ		441,442,960.00	641,237,688.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		398,167,502.00	581,029,330.00
цалин		398,167,502.00	581,029,330.00
Нийгмийн даатгал		43,275,458.00	60,208,358.00
тэтгэвэр болон тэтгэвэрийн шимтгэл		43,275,458.00	60,208,358.00
		594,594,389.49	1,084,401,274.80
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ			
Тогтмол зардал		70,507,131.00	232,185,081.00
гэрэл цахилгаан		29,734,581.00	61,072,396.00
түлш халаалтын зардал		32,545,350.00	156,500,000.00
цэвэр бохир усны зардал		8,227,200.00	14,612,685.00
Үйл ажиллагааны зардал		269,282,771.17	343,516,465.73
Хоол		242,702,117.00	296,471,676.60
Эм		26,580,654.17	47,044,789.13
Бусад бараа үйлчилгээний зардал		254,804,487.32	508,699,728.07
бичиг хэргийн зардал		671,850.00	1,760,780.00
Тээвэр шатахууны зардал		22,362,621.32	32,344,200.00
Шуудан холбооны зардал		794,200.00	1,360,000.00
Дотоод томилолтын зардал		613,900.00	1,472,000.00
Ном хэвлэлийн зардал		8,805,200.00	-
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл		2,387,700.00	6,639,370.00
Хог хаягдал зайлуулах		4,365,000.00	9,234,000.00
Бараа материал акталсны зардал			5,600,000.00
зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал		68,819,209.00	74,150,070.07
Бараа үйлчилгээний бусад зардал		300,000.00	1,805,400.00
төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил,үйлчилгээний төлбөр		3,322,750.00	9,356,056.00
урсгал засварын зардал		9,799,300.00	7,998,000.00
Тавилга			61,690,000.00
элэгдлийн зардал		100,867,310.00	277,226,912.00
Тэтгэвэрт гаргахад олгох тэтгэмж		31,695,447.00	18,062,940.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		1,036,037,349.49	1,725,638,962.80
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН		(36,698,732.72)	9,083,532,990.87
Найдваргүй авлагын алдагдал			6,832,437.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		-	6,832,437.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		(36,698,732.72)	9,076,700,553.87



АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ /төгрөгөөр/

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ	441,442,960.00	641,237,688.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	398,167,502.00	581,029,330.00
цалин	398,167,502.00	581,029,330.00
Нийгмийн даатгал	43,275,458.00	60,208,358.00
тэтгэвэр болон тэтгэвэрийн шимтгэл	43,275,458.00	60,208,358.00
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	513,848,799.77	994,903,952.00
Тогтмол зардал	70,507,131.00	232,185,081.00
гэрэл цахилгаан	29,734,581.00	61,072,396.00
түлш халаалтын зардал	32,545,350.00	156,500,000.00
цэвэр бохир усны зардал	8,227,200.00	14,612,685.00
Бусад бараа үйлчилгээний зардал	443,341,668.77	762,718,871.00
бичиг хэргийн зардал	671,850.00	1,760,780.00
Тээвэр шатахууны зардал	22,362,621.77	32,344,200.00
Шуудан холбооны зардал	794,200.00	1,360,000.00
Дотоод томилолтын зардал	613,900.00	1,472,000.00
Ном хэвлэлийн зардал	8,805,200.00	-
Хог хаягдал	4,365,000.00	9,234,000.00
хоол	278,113,700.00	423,336,700.00
эм	20,324,000.00	56,449,000.00
Багаүнэтэй түргэн элэгдэх зүйл	2,387,700.00	6,639,370.00
зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	58,786,000.00	131,162,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	1,805,400.00
төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил,үйлчилгээний төлбөр	3,322,750.00	9,356,056.00
Тавилга	2,007,000.00	61,690,000.00
урсгал засварын зардал	7,291,200.00	7,998,000.00
бусад зардал	501,100.00	-
төвлөрүүлэх жилжүүлэг	1,000,000.00	48,425.00
нэг удаагын тэтгэмж урамшуулал	4,365,859.00	-
Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж	27,329,588.00	18,062,940.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	955,291,759.77	1,636,141,640.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



**АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ**

	Засгийн газрын оруулсан капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний сан	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцоо
	MNT	MNT	MNT	MNT
2016 оны 01 сарын 01-нээрх үлдэгдэл	870,065,632.00	483,937,190.00	30,789,464.65	1,384,792,286.65
Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	870,065,632.00	483,937,190.00	30,789,464.65	1,384,792,286.65
Тайлант хугацаанд нэмэгдсэн				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Бэлэг хандиваар авсан хөрөнгө				-
Тайлант үеийн үр дүн			9,076,700,553.85	9,076,700,553.85
2016 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	870,065,632.00	483,937,190.00	9,107,490,018.50	10,461,492,840.50



АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ

Үзүүлэлт	Төлөвлөгөө	гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,022,099,500.00	1,635,093,215.00	387,006,285.00	80.86
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,022,099,500.00	1,635,093,215.00	387,006,285.00	80.86
Бараа үйлчилгээний зардал	2,022,099,500.00	1,635,093,215.00	387,006,285.00	80.86
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	780,323,900.00	581,029,330.00	199,294,570.00	74.46
Үндсэн цалин	780,323,900.00	581,029,330.00	199,294,570.00	74.46
Ажил олгогчоос төлөх НДШ	88,036,000.00	60,208,358.00	27,827,642.00	68.39
Бараа үйлчилгээний зардал	1,153,739,600.00	993,855,527.00	159,884,073.00	86.14
Тогтмол зардал	259,647,000.00	232,185,081.00	27,461,919.00	89.42
Гэрэл цахилгаан	90,681,400.00	61,072,396.00	29,609,004.00	67.35
Түлш халаалт	150,600,000.00	156,500,000.00	(5,900,000.00)	103.92
Цэвэр, бохир ус	18,365,600.00	14,612,685.00	3,752,915.00	79.57
Бараа үйлчилгээний бусад зардал	894,092,600.00	761,670,446.00	132,422,154.00	85.19
Бичиг хэрэг	1,956,100.00	1,760,780.00	195,320.00	90.01
Тээвэр, шатахуун	36,746,200.00	32,344,200.00	4,402,000.00	88.02
Шуудан холбоо	2,327,000.00	1,360,000.00	967,000.00	58.44
Дотоод албан томилолт	1,973,300.00	1,472,000.00	501,300.00	74.60
Бусад зардал	709,700.00	1,805,400.00	(1,095,700.00)	254.39
Нормын хувцас зөөлөн эдлэл	131,162,000.00	131,162,000.00	-	100.00
Хоол	524,521,700.00	423,336,700.00	101,185,000.00	80.71
Эм	56,449,000.00	56,449,000.00	-	100.00
Урсгал засвар	71,942,000.00	66,882,600.00	5,059,400.00	92.97
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөл	14,950,000.00	11,161,456.00	3,788,544.00	74.66
Хог хаягдал зайлуулах	16,215,700.00	9,234,000.00	6,981,700.00	56.94
БҮТЭЗ	11,844,800.00	6,639,370.00	5,205,430.00	56.05
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	23,295,100.00	18,062,940.00	5,232,160.00	77.54
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,022,098,500.00	1,635,093,215.00	387,005,285.00	80.86
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	414,720,000.00	33,705,000.00	381,015,000.00	
Төсвөөс санхүүжих	1,607,378,500.00	1,601,388,215.00	5,990,285.00	99.63
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
АЖИЛЛАГСАД БҮГД	127.00	94.00	33.00	74.02
Удирдах ажилтан	1.00	2.00	(1.00)	200.00
Гүйцэтгэх ажилтан	42.00	21.00	21.00	50.00
Үйлчлэх ажилтан	80.00	67.00	13.00	83.75
Гэрээт ажилтан	4.00	4.00	-	100.00
		-		

2017 оны 02-р сарын 14-ны өдөр